



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.25 № 351  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Д.БЯМБАЖАРГАЛ ТАНАА

Аудитын тайлан хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын санхүүгийн тайланг баталгаажуулан хүргүүлж байна.

Аудитаар нийт 74.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 59.0 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 15.9 сая төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу манай газарт ирүүлж, биелэлтийг ханган ажиллахыг зөвлөж байна.

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн зөвлөмжийг хугацаанд нь биелүүлээгүй бол Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", 42.2-т "Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасныг анхаарч ажиллана уу.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

6326050540

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2026/5/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт

Утас: 70342580 Цахим хаяг: [Battsogtd@audit.gov.mn](mailto:Battsogtd@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342495 Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: З.Ганбаатар

Утас: 70342495 Цахим хаяг: [ganbaatarz@audit.gov.mn](mailto:ganbaatarz@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.03.25 № 350  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Д.БЯМБАЖАРГАЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тохижилт үйлчилгээний ангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн ба өргөн тархсан гэж дүгнэлт өгөхөөс татгалзсан, бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүрээнд тайлант онд сумын ОНХС-гаас хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнээс 259.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, ИТХ-аас 26.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ, нийт 285.0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн заалтыг хэрэглэхгүйгээр шууд гэрээ байгуулан ажилласан байна.

6326050543

### **Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгааснаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### **Бусад асуудлын хэсэг**

АДБОУС 2706 10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн тухай, санхүүгийн тайлангийн аудит, аудитын тайлантай холбоотой аудиторын хүлээх үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй тайлбар өгөхөөр хууль тогтоомжоор шаардсан мэдээллийг тусгана.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.БАТЦОГТ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/Мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,212,055.11	3,641,001.78
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,639,491.70	15,809,614.23
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>20,851,546.80</b>	<b>19,450,616.00</b>
	Нийт өр төлбөрийн дүн	17654.81925	276,628.67
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	20,833,891.99	19,173,987.33
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>20,851,546.80</b>	<b>19,450,616.00</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	25,252,041.09	28,291,608.32
	Үйл ажиллагааны зардлын дүн	20,304,990.27	27,985,901.13
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>4,947,050.82</b>	<b>305,707.18</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	-1457201.174	-2,011,785.83
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>3,489,849.64</b>	<b>-1,706,078.65</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17345341.29	20,832,345.74
	Тайлант оны үр дүн	3489849.642	-1,706,078.65
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>20,833,891.99</b>	<b>19,173,987.33</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	21,896,228.11	27,413,301.12
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	18,458,336.48	25,971,352.32
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>3,437,891.63</b>	<b>1441948.799</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>-1865145.863</b>	<b>-1,910,109.08</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>-368913.91</b>	<b>-422380.1828</b>
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,203,831.85</b>	<b>-890,540.46</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1383936.467	2,587,768.32
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,587,768.32	1697227.856
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>14,235,459.00</b>	<b>26,023,954.74</b>
	Урсгал зардал	11,723,104.80	23,956,060.07
	Хөрөнгийн зардал	2012354.2	1,645,514.49
	<b>Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн</b>	<b>23,235,163.40</b>	<b>23,119,655.43</b>
	Улсын төсвөөс санхүүжих	538,785.50	532,194.10
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	237000	322,499.12

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 74.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 59.0 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 15.9 сая төгрөгийн 2 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлэн ажиллаа.

### 3.1 Төлбөрийн акт бичигдээгүй.

### 3.2 Албан шаардлага

1. Сумын Тохижилт үйлчилгээний анги нь 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар татгалзсан дүгнэлт авсан холбогдох төсвийн захирагчид хуулийн хариуцлага хүлээлгэх.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Албан татварын орлого бүрдүүлэлттэй холбоотой.

Илрүүлэлт: Тайлант онд газрын төлбөрийн орлого 6,244.5 мянган төгрөгийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөвт төвлөрөх татварын орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч ажиллах.

Илрүүлэлт: Булган сумын ТТЗ-тайлангаас үзэхэд төлбөртэй үйлчилгээний авлага 8.8 сая төгрөг, ажилчидтай холбоотой 0.9 мянган төгрөг нийт 9.7 сая төгрөгийг авлагатай тайлагнасан байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант онд үүссэн авлагыг барагдуулан ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 11 дүгээр сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЗДТГ	1	10,000.0	1	10,000.0	0	0						
ИТХ	1	88,766.9	0	0	1	88,766.9						
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>98,766.9</b>	<b>1</b>	<b>10,000.0</b>	<b>1</b>	<b>88,766.9</b>						

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		ХТАШ		ХХБШ	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗДТГ	6	36,423.3	3	2,903.3	1	6,520.0	2	27,000.0				
ИТХ	5	34,693.2	2	2,153.2	2	32,540.0	1	0				
ХХС	2	1,303,112.6	0	0	1	8,220.3	1	1,294,892.3				
ОНХС	3	308,800.0	0	0	3	308,800.0	0	0				
<b>Дүн</b>	<b>16</b>	<b>1,683,029.1</b>	<b>5</b>	<b>5,056.5</b>	<b>7</b>	<b>356,080.3</b>	<b>4</b>	<b>1,321,892.3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт  
*/Төгрөгөөр/*

№	Байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл
<b>Төлбөрийн акт</b>				
1	ЗДТГ	Тайлант онд шатахууны зардлаас 1,204.3 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй зарцуулсан.	1,204,300.00	Төлбөрийн акт
2	ЗДТГ	Багийн дарга нарт хээрийн хувцас 1,115.0 мянган төгрөгөөр худалдан авч өгсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг зөрчсөн	1,115,000.00	Төлбөрийн акт
3	ЗДТГ	Төрийн албаны зөвлөлөөс ирсэн алба хаагчдад 584.0 мянган төгрөгөөр Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, 15.1.7 заалтыг зөрчиж айраг худалдан авч өгсөн.	584,000.00	Төлбөрийн акт
4	ИТХ	Тайлант онд сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас замын тэмдэг, тэмдэглэгээг хийж гүйцэтгэх 9,300.0 мянган төгрөгийн ажлыг хүлээж аваагүй, гэрээний тугацааг 124 хоног хэтрүүлсэн, гэрээний тусгай нөхцөлд заасан хоног тутамд 0.1 хувийн алданги 1,153.2 мянган төгрөгийг суутган тооцоогүй.	1,153,200.00	Төлбөрийн акт
5	ИТХ	Тайлант онд сумын ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлаас нэг төлөөлөгч 2,000.0 мянган төгрөгийг авсан нь сумын ИТХ-ын төлөөлөгч 1,000.0 сая төгрөг хүртэл дүнг зарцуулахаас тус төлөөлөгчид 1,000.0 мянган төгрөгийг илүү олгосон.	1,000,000.00	Төлбөрийн акт
Нийт дүн			5,056,500.00	
<b>Албан шаардлага</b>				
1	ЗДТГ	Тайлант онд 2 дугаар сургуулийн 1В ангийн ширээ, сандал шинэчлэхэд 17,500.0 мянган төгрөгөөр "Энх Алтун" ХХК-тай гэрээ байгуулсан ч сургуулийн боловсруулсан төсөлд заагдсан эд материалыг бүрэн нийлүүлээгүй	6,520,000.00	Албан шаардлага
2	ИТХ	Тайлант онд сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 26,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авах ажлыг шууд гэрээ байгуулсан.	26,000,000.00	Албан шаардлага
3	ИТХ	Тайлант онд сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас замын тэмдэг, тэмдэглэгээг хийх 9,300.0 мянган төгрөгөөр гүйцэтгэсэн ажил нь гэрээнд заагдсан ажлаас хийж гүйцэтгэх 1-р сургуулийн тойрог хэсэгт хашлага хийх ажлыг 2,760.0 мянган төгрөгөөр гүйцэтгэсэн 6,540.0 мянган төгрөгөөр нь гэрээнд заасан ажил хийгдээгүй.	6,540,000.00	Албан шаардлага
4	ОНХС	Тайлант онд инженерийн шугам сүлжээний салбар шугамын зураг төсөв 104.0 сая, Багуудын гудамж хоорондын зам засвар 6,54,3,2,1 дүгээр багуудын зам засвар 30 сая, Багуудын хорооллын гэрэлтүүлэг камержуулалт 100.0 сая, өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд аюулгүй	259,000,000.00	Албан шаардлага

		нөөц бүрдүүлэх 25.0 сая нийт 4 төсөл арга хэмжээг хэсэгчлэн задалж шууд гэрээ байгуулсан		
5	ОНХС	Булган сумын Домын дэвсгийн тоглоомын талбай 4 дүгээр баг 20.0 сая, Булган 6 дугаар багийн тоглоомын талбайг сэргээн засварлах 19.8 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээний гэрээний хугацаа 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр дууссан ч гэрээгээр гүйцэтгэх ажил дутуу 6 дугаар багийн тоглоомын талбайн санхүүжилт 75 хувь, домын дэвсгийн тоглоомын талбайн санхүүжилтийг 100 хувь олгосон.	39,800,000.00	Албан шаардлага
6	ОНХС	6 багийн гудамж хоорондын зам засвар 30,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээнээс 2 ба 4 дүгээр багийн засварласан зам нь эвдрэл гэмтэлтэй.	10,000,000.00	Албан шаардлага
7	ХХС	Тайлант онд зээлийн хүүгийн авлагаас 33,445.7 мянган төгрөг төвлөрч 11,564.9 мянган төгрөгийг урамшуулалд зарцуулсан нь нь ХХС-гийн журамд заагдсан хүүгийн 10 хувь хүртэл гэж зааснаас 8,220.3 мянган төгрөгийг илүү зарцуулсан.	8,220,284.00	Албан шаардлага
Нийт дүн			356,080,284.00	
<b>Зөвлөмж</b>				
1	ЗДТГ	Тайлант онд төсөл хөтөлбөрийн зардлаас дуучин Г.Бат-Эрдэнэд 1,000.0, н.Энхмөрөн 2,000.0, Алтангэрэл 1,000.0, Мөнгөнтуяа 1000.0, Равжир 1,500.0, Дугарсүрэн 500.0 нийт 7,000.0 мянган төгрөгийг олгосон.	7,000,000.00	Зөвлөмж
2	ЗДТГ	Төсөл хөтөлбөрийн зардлаас тайлант онд Цагдаагийн газарт шилжүүлсэн 20,000.0 мянган төгрөгийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулгахад Цагдаагийн албаны тухай хуулийн 94 дүгээр зүйлийн дагуу зарцуулаагүй, зориулалт бусаар зарцуулсан	20,000,000.00	Зөвлөмж
3	ИТХ	Тайлант онд 23,299.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан авалтыг хийгээгүй.	-	Зөвлөмж
4	ХХС	ХХС-ийн авлагын эцсийн үлдэгдэл болох 1,294,892.3 төгрөгийн холбогдох иргэн, хоршоодтой авлагыг үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.	1,294,892,316.68	Зөвлөмж
Нийт дүн			1,321,892,316.68	
<b>Залруулсан алдаа</b>				
1	ЗДТГ	Тайлант онд Монголын Таеквондогийн холбоод мөрийн хөтөлбөрийн зардлаас 10,000.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэхээс ЗД нөөц хөрөнгөөс зарцуулсан өглөгөөр тусгаагүй	10,000,000.00	залруулга
2	ИТХ	тайлант онд 88,766.9 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэсэн ч мөнгөн хөрөнгийн биет ба биет бус хөрөнгийн зардал ангилалд бүртгээгүй.	88,766,860.00	Залруулга
Нийт дүн			98,766,860.00	